



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 74,089,344.00 (далан дөрвөн сая наян есөн мянга гурван зуун дөчин дөрвөн) төгрөгийн балансын үнэ, 22,432,606.93 (хорин хоёр сая дөрвөн зуун гучин хоёр мянга зургаан зуун зургаан төгрөг өрэн гурван мөнгө) төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Цаг уур, орчны шинжилгээний газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, хууль зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Эрдэнэхишиг, Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтувшин нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээнцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001534

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 04 дүгээр сарын 03ны өдрийн
43 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

Д/А	Автомашины нэр, улсын дугаар, арлын дугаар, марк	Ашиглалтад орсон он	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Ландкруйзер 200, 04-83 УНҮ (арал-1gra567252)	2016	74,089,344.00	ш	1	74,089,344.00	51,656,737.07	22,432,606.93
	Нийт дүн					74,089,344.00 (далан дөрвөн сая наян есөн мянга гурван зуун дөчин дөрвөн)	51,656,737.047 (тавин нэгэн сая зургаан зуун тавин зургаан мянга долоон зуун гучин долоон төгрөг дөчин долоон мөнгө)	22,432,606.93 (хорин хоёр сая дөрвөн зуун гучин хоёр мянга зургаан зуун зургаан төгрөг ерэн гурван мөнгө)